

ДОТООДЫН

ЗАХ ЗЭЭЛИЙН ДОЛОО
ХОНОГИЙН ТОЙМ



2025.07.07

Дотоодын зах зээлийн онцлох мэдээ

ТОВЧ

- Эрдэнэ Ресурс “Тэрэг уул” гэх зэс-алтны ордыг эзэмшиж эхлэв
- TSX:ERD MSE:ERDN хувьцааны ханш үргэлжлэн өсөх магадлалтай
- Монгол улсын гадаад валютын улсын нөөц 6-р сард 5,206.07 сая ам.доллар болж 2-р сараас хойш тасралтгүй өссөөр байна

МХБ-ийн индексийн өгөөж

Индекс	Долоо хоног	Сар	Жил
ТОП 20	1.01%	-0.71%	25.47%
MSE A	1.81%	-1.21%	20.27%
MSE B	3.68%	-0.21%	34.89%

2025/06/30 – 2025/07/04

Идэвхтэй арилжаалагдсан үнэт цаас

Симбол	Үнийн дүн
AARD	1,132,158,772.00
KHAN	522,565,375.00
MGLA	452,345,610.00
XAC	155,656,008.82
GLMT	84,674,703.00

2025/06/30 – 2025/07/04

Өндөр өсөлттэй үнэт цаас

Симбол	Хаалтын ханш	Өсөлт %
GTL	44,080.00	32.21%
HGN	64.00	28.00%
ADU	356.00	18.67%
TNGR	5,985.00	16.67%
SHG	1,840.00	15.00%

2025/06/30 – 2025/07/04

2025 он 07-р сарын 07

Зах зээлийн
үнэлгээ тэрбум ₮

12,139

ТОП-20 индекс

49,352

MSE A

17,888

MSE B

14,757



МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

ДНБ өсөлт

2.4%

2024 - I улирал

Инфляц

8.3%

2025-05 сар

ГВУН(сая\$)

5,206.07

2025-06 сар

Бодлогын

хүү

12.0%

ЗГ-ын бондын
өгөөж

6.6%

USD/MNT

3,583.60

2025-07-06



Эдийн засгийн мэдээлэл

ХАРЬЦАА ҮЗҮҮЛЭЛТҮҮД БУУРЧ ХУВЬЦААНЫ ХАНШ ӨСӨХ ХАНДЛАГАТАЙ БАЙНА



Зураг 1. ТОП-20 индекст багтах компаниудын P/E (2025.06.24)



P/E буюу үнэ-ашгийн харьцаа бол хувьцаа хэр үнэтэй байгаа эсэхийг дүгнэх суурь үзүүлэлт бөгөөд ирээдүйн ханшийн чиг хандлагыг тодорхойлох хэрэгслүүдийн нэг. Тэгвэл уг харьцаа бага байх тусам хувьцааны үнэ хямд байгааг илэрхийлдэг.


ТОП-20 индексийн үнэ-ашгийн харьцааны дундаж 5.51 байгаа бөгөөд ихэнх компаниуд бодит үнэлгээнээс доогуур үнэлэгдсэн байна.

Дунджаас доогуур харьцаа үзүүлэлттэй байгаа компаниудын хувьцааны ханш сүүлийн хагас жилд өсөх боломж өндөртэй гэсэн үг. Мөн 2024 оны байдлаар ТОП-20 индексийн дундаж P/E харьцаа 8.4 байсан бол өнөөдөр 5.51 болтлоо буурчээ.

*Банкны салбарын P/E=3.42, Банкнаас бусад салбарын дундаж P/E=6.38

Тэгвэл банкнуудын хувьцааны харьцаа үзүүлэлт банкнаас бусад салбаруудын дундаж үзүүлэлтээс 2 дахин бага байгаа учир цаашид банкнуудын хувьцаа өсөх боломж хэвээр байсаар байна.


Хүснэгт 1. Монгол улсын ГВУН /сая ам.доллар/





Зах зээлийн мэдээлэл

ЭРДЭНЭ РЕСУРС “ТЭРЭГ УУЛ” ГЭХ ЗЭС-АЛТНЫ ОРДЫГ ЭЗЭМШИЖ ЭХЛЭВ



Тэрэг Уулын хайгуулын тусгай зөвшөөрөл нь нийт 6,694 га газрыг хамрах бөгөөд 2023 оны 4-р сарын 5-нд олгогдсон, Монгол Улсын Ашигт малтмалын тухай хуульд заасан нөхцөл хангагдвал уул уурхайн ашиглалтын тусгай зөвшөөрөлд 12 жилийн дотор шилжих боломжтой юм. Уг талбай нь Оюу Толгойн ашиглалтын лицензийн хилийн өмнөд хэсгээс 5 км, мөн Entrée Gold болон Оюу Толгойн хамтарсан төмөр замын зэс-алтны ордоос өмнө зүгт оршино.

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци (TSX:ERD | MSE:ERDN) нь Өмнөговь аймгийн Ханбогд, Баян-Овоо сумдын нутагт орших “Тэрэг Уул” зэс-алтны хайгуулын талбайг 80 хүртэл хувиар эзэмших сонголтын гэрээ байгуулсан талаар албан ёсоор мэдэгдлээ. Тус талбай нь дэлхийн хэмжээний томоохон ордуудын нэг болох Оюу Толгой ордоос ойролцоогоор 10 км-ийн зайд оршиж байгаа нь стратегийн хувьд онцгой байршилд тооцогдож байна.

TSX:ERD MSE:ERDN ХУВЬЦААНЫ ХАНШ ҮРГЭЛЖЛЭН ӨСӨХ МАГАДЛАЛТАЙ




TSX:ERD, MSE:ERDN хувьцаа энэ оны сүүлийн хагаст өсөлт үргэлжлэн 1.30 канад долларт хүрэх магадлал өндөр байна. Үүнд алтны ханшийн өсөлт болон Баян хөндийн алтны уурхайн олборлолт эхлэх зэрэг нь нөлөөлнө. Мөн тус компанийн хувьцааг сонирхож байгаа томоохон хөрөнгө оруулагчдын тоо улам нэмэгдсээр байна. Үүний нэг илрэл нь компанийн хувьцааг АНУ-ын OTCQB Венчур зах зээлд албан ёсоор бүртгүүлж, ERDCF тикертэйгээр арилжаалж эхэлснээ албан ёсоор мэдэгдлээ.

ДОТООДЫН ХУВЬЦААНД ХЭЗЭЭ ХӨРӨНГӨ ОРУУЛАХ ВЭ?

ТОП-20 индексийн хэлбэлзэл (2015-2025)

	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025	ДУНДАЖ
1 сар	-2.10%	-1.00%	5.40%	-4.20%	7.50%	0.90%	10.50%	1.90%	3.50%	7.00%	2.90%	2.90%
2 сар	-3.50%	-3.00%	-0.90%	-0.10%	-0.60%	-0.90%	29.20%	-4.60%	2.40%	5.50%	1.70%	2.30%
3 сар	-3.50%	-5.10%	4.60%	-1.00%	-2.60%	-4.00%	31.20%	-6.10%	0.50%	1.90%		1.60%
4 сар	-3.00%	-1.50%	2.50%	-4.60%	-3.70%	-8.70%	4.10%	-0.90%	-5.20%	-3.30%		-2.40%
5 сар	-2.40%	-1.20%	-1.60%	-2.00%	0.30%	-2.10%	1.20%	-6.70%	0.50%	-0.40%		-1.40%
6 сар	13.90%	5.20%	-1.60%	0.90%	-1.80%	-1.00%	-7.70%	-3.70%	-0.60%	0.80%		0.50%
7 сар	-2.60%	10.80%	8.20%	-1.00%	3.60%	2.00%	-1.10%	-0.80%	1.10%	9.80%		3.00%
8 сар	-6.70%	-1.80%	8.70%	-0.90%	-2.80%	1.60%	7.70%	4.60%	0.00%	3.50%		1.40%
9 сар	-0.40%	-7.40%	16.60%	3.50%	-3.20%	2.70%	27.50%	-1.50%	-5.40%	-1.30%		3.10%
10 сар	-0.60%	-2.70%	16.90%	2.10%	-3.60%	1.60%	-10.00%	-1.90%	0.60%	0.20%		0.30%
11 сар	-2.90%	-3.40%	9.30%	-2.00%	0.00%	0.50%	-2.40%	1.10%	4.60%	1.80%		0.70%
12 сар	-3.60%	7.00%	0.10%	0.10%	1.90%	3.30%	5.80%	5.40%	5.00%	2.00%		2.70%

ТОП-20 индексийн сарын дундаж хэлбэлзэл (2015-2025)



Монголын ТОП-20 индексийн дундаж хэлбэлзлээс харахад 1-3 сар, 7-9 сар, 12 саруудад өсөлт давамгайлдаг байна.

Ямар стратеги баримтлах вэ?

- Ногдол ашиг хүртэхийг зорьж буй бол 1-3 сард хувьцаа худалдаж авах нь тохиромжтой.
- Хямд үнээр хувьцаа авах боломж хайж байгаа бол 4-5 сард зах зээлийн уналтыг ашиглах хэрэгтэй.
- 7-9 сард зах зээл өсөх магадлалтай тул эрт худалдан авч, өсөлтийг ашиглах боломжтой.
- Жилийн эцэст (12-р сар) дунд хугацааны өсөлт ажиглагдах хандлагатай тул урт хугацааны хөрөнгө оруулалтад тохиромжтой үе.